

ЛАМ ХУВРАГИЙН САХИЛ САНВААР ХУУЛЬ ЦААЗАД ХЭРХЭН ТУССАН ТУХАЙ

Г.БАЯРМАА

Товч агуулга: 1911 оны 12 сарын 29-нд Халх Монгол төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, VIII Богд Жибзундамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанд өргөмжлөн, улсынхаа засаг төрийн аппаратыг эмхлэн байгуулсан билээ. Улмаар шинэ тулгар улсаа хөгжүүлэх шинэчлэлийн олон бодлого хэрэгжүүлж эхэлсэн агаад үүний дотор эрх зүйн шинэчлэл чухал байр эзэлдэг. Юуны түрүүнд Чин улсаас тус оронд тогтоосон хуулийг хүчингүй болгож, өөрийн орны шинэ хууль боловсруулан гаргах хүртэл нийгмийн амьдралын олон хүрээний асуудлыг зохицуулсан дүрэм хэмжээг тогтоож байсны нэгэн илрэл бол Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Жинхэнэ дагаж явах хууль дүрэм хэмээх баримт бичгийг боловсруулан 1913 оноос мөрдүүлж эхэлсэн байдаг. Тус хууль дүрмийн 1, 12 -р зүйлд Монголын нийгмийн томоохон бүлэг, давхраа болох лам хүний сахил санваарын асуудлыг нарийвчлан тогтоож өгчээ. Иймээс энэхүү өгүүлэлд төрөөс гаргасан хууль дүрэмд уг асуудлыг нарийвчлан оруулж өгсний учир юу байв. Бурханы шашны лам хуврага хүн номын ёсыг зөрчин сахил санваараа алдах үзэгдэл нийгэмд түгээмэл гарах болсон шалтгаан. Энэхүү асуудлыг таслан зогсоох гэсэн хүрээ хийдийн дотоод дүрэм, цаашлаад төрөөс мөрдүүлж байсан хууль цаазуудад хэдийнээс тусгагдах болсон, хэрэг хийвээс хэрхэн шийтгэж байсан зэргийг Их шавийн харьяат сүм хийдүүдэд суух лам нарын жишээгээр Монгол Улсын Үндэсний Төв Архивд хадгалагдан буй Шавийн яамны баримтууд болон Жинхэнэ дагаж явах хууль дүрэм зэрэг хууль цаазын бичгүүдийг ашиглан тодруулахыг зорив.

Түлхүүр үг: Жибзундамба, хувраг, сахил, дүрэм журам

Бурханы шашны хувраг хүний сахил санваарын асуудал нь шашин судлалын, түүхийн, эрх зүйн судлагдахуун болсон сэдэв болно. Тэдгээр ухаанууд асуудлыг өөр өөрийн судлагдахууны түвшинд тус тусдаа авч үзэж, судалсан байдаг. Түүхийн тухайлсан эх сурвалжийг задлан судлах явдал нь лам хувраг хүнд шашны сахил санваараа ариун нандин байлгах, ёс жудагтай байх зэрэг лам нарын ёс зүйн асуудлыг тухайн үед үед ямар хэмжээнд авч үзэж байсныг тодруулах нь Монголын бурхан шашны түүхийн судалгаанд зохих хувь нэмэр оруулах зүйл юм.

Шашин судлалын ухаанд Винай ёс шагшаабадын судалгааг үе үеийн энэтхэг, төвөд, монголын эрдэмтэд¹ хийсээр ирсэн, одоо ч хийсээр байна. Монголын хутагт хувилгаад, сүм хийд, Их шавь, Их хүрээний судалгааг олон эрдэмтэд хийсэн билээ. Тухайлбал: С.Пүрэвжав² XVII-XX зууны эхэн үеийн Монголын бурханы шашны түүхийн судалгаа хийхдээ Их хүрээний аймаг, дацангуудийн бүтэц, дотоод дүрмийн судалгааг хийсэн. Дотоод дүрмүүдийн нэг хэсэг болох лам хүнийг сахил санваарын асуудлыг товч хөндөн үзжээ. Мөн Ж.Болдбаатар, З.Нинжбадгар³ нарын судалгаанд энэхүү асуудал цухас дурдагдсан байна. Монголын уламжлалт эрх зүйн түүхийг судалдаг эрдэмтдээс⁴ Б.Баярсайхан Халх Журам, Улаан хацарт, Жинхэнэ дагаж явах хууль дүрмүүдийн эх бичгийн судалгааг хийхдээ уг сурвалжуудын заалтууд, тухайлбал лам нар эмс охидтой хольцолдох тухай заалтуудыг харьцуулсан байдлаар авч үзэн 1780- аад оноос 1920 оны эхэн үеийг хүртэл уг харилцааг зохицуулж байсан арга, зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага ижилхэн байсан зэргийг тодруулсан судалгаа хийсэн байна.

Иймээс би энэхүү асуудлыг нарийвчлан тодруулан үзэхдээ Монгол улсын хэмжээнд 1913 оноос мөрдөгдөж эхэлсэн Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн 12 зүйлийг гол болгон авч үзлээ. Монголын нийгмийн нэгэн давхаргыг бүрдүүлж байсан лам нар номын ёсыг зөрчин сахил санваараа алдах болсны шалтгаан, энэхүү асуудлыг зохицуулах гэсэн хүрээ хийдийн дотоод журам цаашлаад төрийн хууль цаазуудад уг зөрчлийг хуульчлан өгөх болсныг дараах байдлаар авч үзье.

- Хүрээ хийдийн лам нар сахил санваараа алдах болсон шалтгааныг тухайн үеийн нийгмийн байдалтай холбон тайлбарлах.
- Тэрхүү явдлыг таслан зогсоох гэсэн Их шавийн Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нарын үйл ажиллагаа, дотоод дүрэм журам, төрийн хууль цаазын зүйл заалтад орох болсон тухай

¹ Тухайлбал, Төгс Цогт Атиша (982-1054) Их билигтийн мөрд орохуйн үндэс хэмээн сурах аргын эх сурвалжид сурах ёсыг эрхэм болгоход сахих сэтгэлийг гагцхүү санваар сахих ёсоор гүйцэтгэх ёстой хэмээн сургаж байсныг Монголын эрдэмтэн лам нар уламжлан авч номтгохын сургаалаар Агваанхайдав, бичээч цорж Агваандорж, Зая хүрээний хамба Лувсанжамц, Их хүрээний гавж Жамц нар винайн сургаалаар тайлбар болон бие даасан зохиол бичиж байсан. Эдгээр сургаал зохиолууд нь хожмын судлаачдын судлагдахуун болж байна.

² Пүрэвжав, С. Хувьсгалын өмнөх Их хүрээ. Улаанбаатар: 1961; *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, УБ., 1978.

³ Болдбаатар, Ж. *Монголын бурханы шашны лам хуврага*, Улаанбаатар: 2010; Нинжбадгар, З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхэн)*, Улаанбаатар: 2014; Нинжбадгар, З. “Яамны дүрэм-ийн тухай (эх бичгийн судалгаа)”, *Historia Mongolarum* №267 (33), 2001.

⁴ Баярсайхан, Б. *Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт)*. Улаанбаатар, 2010, Баярсайхан, Б., Урангуа, Ж. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа)*. Улаанбаатар: 2004, Содовсүрэн, Б. *Хувьсгалын өмнөх Монголын тор ба хууль цааз (1911-1920)*, Улаанбаатар: 1989.

- Гэм алдаа гаргасан хувраг нарыг хэрхэн шийтгэсэн байдал зэргийг баримтуудад түшиглэн тодруулахыг оролдлоо.

Жинхэнэ дагаж явах хууль дүрэм

1911 онд Монголчууд төрийнхөө тусгаар тогтнолоо сэргээн, шинэ тулгар улсаа хөгжүүлэх олон шинэтгэлийн бодлого хэрэгжүүлсэн. Энэхүү бодлогын хүрээнд Чин улсаас Монголд хэрэгжүүлж байсан хууль цаазыг халж, шинэ нөхцөлд тохирсон хууль дүрмийг боловсруулах ажлыг эхлүүлсэн юм.

Судлаач Б. Содовсүрэн ...Олноо Өргөгдсөний тэргүүн оноос нааш олон яамнаас айлтгаад тогтоосон ба тусгайлан зарлиг буулгаж нийтээр дагаж буй хэргийн товчоо хэмээх данс бүртгэлд 1911-1917 оны 4 сар хүртэлх хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг⁵ байна гэсэн тоо гаргажээ. Тэдгээрийн нэг нь ...Таван яам хамт нийлж хувьсан тогтоож гаргасан Жинхэнэ дагаж явах хууль дүрэм гэх эрх зүйн баримт бичиг юм. Энэхүү хууль 1918 онд Зарлигаар Тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн Бичгийг⁶ үйлчлэх хүртэл нийгмийн харилцааг зохицуулж байжээ хэмээн үзсэн байна.

Ингээд энэхүү Жинхэнэ дагаж явах хууль дүрэм 12 зүйлтэй. Тэдгээрт хүрээ хийд, лам нарын асуудлыг нарийвчлан зохицуулж өгсөн байна. Үүнийг нэг бүрчлэн тоймлон үзүүлвээс,

Нэгдүгээр зүйлд: Лам нар хэрэг зөрчил гаргаваас ...аливаа Нийслэл хүрээнд сууж дацан аймагт захирагдан хурал сургууль үйлдэж бүхий мяндагтан ба гэлэн, гэгэл, санваартантай буюу гэнэн боловч, хурал сургуулийн ба алба хаах лам нарыг хэргийн учир зарлан байцаах шүүх хэрэг тохиолдвоос урьдаар Эрдэнэ Шанзудбын яамнаа мэдэгдэн залруулах бахэрэв шашны мяндагтан санваартанд шүүх хэрэг тохиолдвоос Хамба номун ханд сонсгосон хойно гүйцэтгэн шийтгүүлэж⁷ байхаар хэм хэмжээ тогтоож өгсөн байна.

Дүрмээр лам хуврагтай холбоотой гэмт хэргийг шүүн хэлэлцэхдээ Эрдэнэ шанзудбийн яаманд урьдчилан мэдэгдэх, шашны мяндагтан нарыг шүүх хэрэг тохиолдвоос Хамба номун ханд сонсгосны дараа уг хэргийг шийтгэж байхыг хуульчлан өгсөн нь дараах учир шалтгаантай болов уу.

- Лам хувраг хүн хэрэг хийвээс шүүн таслахын өмнө заавал шарыг шувтлан сахил санваарыг түр болон бүр мөсөн эвдэж хар болгосны дараа хэрэг хэлэлцдэг журамтай.

⁵ Содовсүрэн, Б. *Хувьсгалын өмнөх монголын тор ба хууль цааз* (1911-1920), Улаанбаатар: 1989, 56.

⁶ ЗТМУХЗБ- хэмээн товчлох болно.

⁷ Баярсайхан, Б., Урангуа, Ж. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа)*. Улаанбаатар: 2004, 63.

- Эрдэнэ шанзудбын яамны лам нартай холбоотой шүүн таслах, байцаан шийтгэх хуучин эрхийг хуулиар баталгаажуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, Халхын шарын шашны тэргүүн Жибзундамбын хүрээнд ирж шашны эрдэмд суралцах лам нар бүгд Их шавийн харьяат биш боловч харьяатын нэгэн адил Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нарт шууд захирагдаж, анхан шатны нэгжийн хувиар аливаа хөнгөн, хүнд хэргийг эрхлэн шүүн, хүнд хэрэг болбоос Шүүх яамнаа мэдүүлэн шилжүүлэн шийтгүүлэх эрхтэй байсных аж.
- Өндөр хэргэм зэрэг бүхий лам нарыг хэрэг өдүүлбээс төрийн албан тушаалтан өөрийн дураар шууд байцаах, шүүх эрх үгүй болгож хуульчлан өгсөн нь Богд Жибзундамба хутагт Монгол улсын хаан болж, түүнийг дагаад лам нарын эрх мэдэл дээшилсний нэг илрэл гэлтэй. Энэ нь зөвхөн Их шавийн мяндагтан нарт үйлчлэх хэрэг бус, Халхын олон тамгатай ба тамга үгүй хутагт хувилгаад, орон нутаг дахь сүм хийдүүдийн хэргэмтэн лам нарт нэгэн адил үйлчлэж байсан болов уу. Үүнийг хойшид тодруулан үзүүштэй мэт. Учир нь “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм” гэх эрх зүй баримт бичиг нь зөвхөн Нийслэл хүрээнд хэрэгжүүлж байсан хууль биш билээ.

Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн 12 дугаар зүйлд лам хүний дагаж явбал зохих хэм хэмжээг гучин хоёр зүйлээр тогтоон өгсөн байна. Энэ тухай лам нарын сахил санваар ба зөрчлийн тухай хэсэгт тодорхой өгүүлэх болно.

Өгүүлэн буй үед ийнхүү юуны түрүүнд хууль дүрэм батлан гаргаж, лам нарын ёс зүйн асуудлыг тийнхүү чухалчлан хуульчилж өгсөн нь Монголын нийгэмд үлэмж нөлөө бүхий бөгөөд тооны хувьд нэлээд жин даах нэгэн давхрааны ёс зүйн хэм хэмжээг тогтоож өгсөн явдал нь өөрөө нэн сонирхолтой зүйл бөгөөд тухайн үеийн нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээнээс үүдэлтэй гарсан зүйл болох талаар доор дэлгэрүүлэн авч үзье.

Лам нар

XVII-XX зууны эхэнд Монголын нийгэмд хувраг лам хэмээх давхараажил бүрэлдэн бий болсон байв. Монголчууд 6-7 насны хөвгүүдээ лам багшид шавь болгон шашны бага сургуулийн боловсролыг 3-4 жилд эзэмшүүлдэг байжээ. Тэдгээр хөвгүүд сахил санваарт үнэнч байхаа тангараглаж хурал номын ажилд оролцох эрхийг олж авдаг байв. XX зууны эхэн үед Монголд ирсэн Унгарын аялагч Иозеф Гелета банди нарын сахил хүртэх ёслолын тухай өөрийн тэмдэглэлдээ бичиж үлдээсэн байдаг. Түүнд: Хийдийн тэргүүн лам тэрхүү залууст сахил хүртээхдээ тэднийг дараах байдлаар нэгэн дуугаар хэлүүлнэ.

-Би амьтны амийг хэзээ ч хорлохгүйгээ андгайлж байна.

-Би хүний юмыг хэзээч авахгүйгээ андгайлж байна.

-Би алив садар самууныг тэвчин үл үйлдэнэ.

-Би хэзээч худал хэлэх гүжир гүтгэлгийг үйлдэхгүй.

-Би хэзээ ч архи сархад хэрэглэхгүй.

-Би хэзээ ч мацгийн өдөр хоол идэхгүй

-Би зугаалан цэнгэхийн тулд элдэв хөг дуу, бүжигт үл автахаа андгайлъя.

-Би хэдийгээр дунд нь амьдарч байвч алт мөнгө цуглуулахгүйгээ андгайлж байна⁸ хэмээн тангараг өргүүлж, лам хэмээх давхаргад албан ёсоор багтдаг байжээ. Энэхүү эрхийг төрийн яамдаас баталгаажуулдаг байжээ. Лам болох хүн анх хошууны тамгийн газартаа хүсэлт гаргаж, засаг ноён харьяа Чуулган даргын газарт уламжлан, цаашлаад ГМТЗЯЯ-наа мэдэгдсэнээр хошууны лам нар Тэмдэгт бичиг, магадаас гарахын тэмдэг олгуулахыг Журган мэдэн зөвшөөрөл олгодог байв. Олноо өргөгдсөн Монгол улсын үед Дотоод яамны Түшмэлийн хэлтэс эрхлэн мэдэх болжээ.

Монголын лам нарын тооны талаар Оросын эрдэмтэн И.М.Майский бүтээлдээ бичжээ. Түүний судалгаагаар, Халхын хэмжээнд 1918 онд ...нийт 237203 эрэгтэйчүүд тоологдсоны 105577 лам буюу ...бүх насанд хүрсэн эрчүүдийн 44,6 % энэ бол дундаж тоо⁹ гэжээ. Тухайлбал: Их шавийн өрх, хүн амд лам нарын эзлэх хувийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Их шавийн өрх, хүн амын данс¹⁰

Он	Өрх	Хувраг	Хүн ам	Шавийн хүн амд хуврагуудын эзлэх хувь
1772	11200	9472	63880	14,8%
1830	17035	21816	83982	26%
1837	15153	19245	76917	25%
1870	20093	10469	65103	16%
1882	9869	22184	64263	34,5%
1909	7975	16455	41880	39,2%
1915	6654	16954	38645	42,5%
1918	8833	21180	49878	42,5%

⁸ Болдбаатар, Ж. *Монголын бурханы шашны лам хуврага*, Улаанбаатар: 2010, 69.

⁹ Майский, И. М. *Орчин үеийн Монгол: Автономит Монгол XX зууны гараан дээр*. Улаанбаатар: 2001, 39.

¹⁰ Нинжбадгар, З. *Живзундамба хутагтын шавийн захиргаа (ХҮП-XX зууны эхэн)*, Улаанбаатар: 2014. 163; МУҮТА А-74 Д-1 ХН-327, А-74 Д-1 ХН-514.

Дээрх баримтуудад Их шавийн хүн ам 1830 оныг хүртэл тогтмол өсөлттэй байсан бол 1837 оноос хойш тогтмол буурч эхэлжээ. Энэ нь сум эрийг шавь өргөх үгүй гэсэн Чингийн хууль тогтоомж нөлөөлөхийн сацуу, шавьд өргөгдөж байгаа хүмүүсийн олонхи нь лам нар байсан зэрэг нь нөлөөлжээ. И.М.Майскийн бүртгэлээр¹¹ Их шавьд лам, хар нийлсэн 29976 эрэгтэйчүүд байгаагийн 21309 буюу 71% нь лам нар байсан байна. Эдгээр лам нар Их шавийн харьяа сүм хийдүүд болон Хүрээнд ирж шашин номын ажлаа хийдэг байжээ. Тухайлбал, мөн Жибзундамба хутагтын Их хүрээнд шашны гүнзгийрүүлсэн боловсрол эзэмших гэж Монголын өнцөг булан бүрээс олон лам нар ирж амьдран суудаг.

Хүрээнд 1889 онд 13850,¹² 1919 онд 20000 орчим лам¹³ байсан гэсэн тоо баримтууд байна. Эдгээр тоо баримтуудаас харвал лам нарын тооны өсөлт, нэг газар дахь олон лам нарын бөөгнөрөл зэрэгтэй уялдан лам нартай холбоотой хууль цаазыг боловсруулах, лам нарын ёс зүйн асуудлыг нарийн хуульчилж өгөх, нийгмийн шаардлага болсон зүйл байжээ. Лам нар дээр өгүүлсэн ёсоор номыг шүтэн эгэлийн амьдралаас хол байх андгай тангараг өргөдөг байсан боловч XIX-өөс XX зууны эхэн үед гэхэд лам нарын давхраажилт олон бүлгүүдээс тогтох болсон. Тухайлбал, сахил санваараа чанга сахин номын мөрийг хөөгч нэг хэсэг байхад номын ёсыг умартан эмс охидтой холбогдох, эхнэртэй лам, хулгай ч лам, зэрэг харын амьдралаар амьдрагч лам нар олноор бий болж байсан нь бурханы шашны ёс зүйг зөрчсөн үйлдлүүд байв.

Сахил санваар ба зөрчлийн тухай

Лам нарын гаргаж байсан хэрэг зөрчлүүд бүгд бурханы шашинтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүд байв. Сахил санваарыг шашинд ийнхүү тайлбарладаг байна.

Бурханы шашинд билиг билгийн үндсийг олохуй буюу гэгээрэлд хүрэхэд бурханы зарлиг, номлол сургаалийн цогц, сургаалын багш гуравт итгэн сайн үйлийг бүтээхүй, нүгэлт үйлийг тэвчихүй суртахууны эрхэм чанар нэвтэрхүй хэмээн үздэг. Үүнээс үзвэл лам хуваргууд нь бурханы номыг баригч, олон нийтийг оюун санааны хувьд хөтлөн дагуулагч хүн юм. Лам хувраг хүний ариун ёс суртахуун, мөрдөж явах жаяг, сахил санваарыг Бурхан багшийн үеэс зарлиглаж

¹¹ Майский. И. М. *Орчин үеийн Монгол*. Улаанбаатар: 2001, 18

¹² Пүрэвжав, С. *Хувьсгалын онох Их хүрээ*, Улаанбаатар: 1961, 30.

¹³ Өлзийбаатар, Д. "Хутагтын хүрээнээс Нийслэл хүрээ: ойлголтын ижилсэл ба зорүүд нэмэх хоёр санаа", *Нийслэл хүрээ 100 жил эрдэм шинжилгээний эмхтгэл*, Улаанбаатар: 2012, 47

ирсэн байна.¹⁴ Бурхан багшийн зарлигийн хураангуй Ганжуур 16 боть 93-108 боть, шаштир хураангуй Данжуурын 16 боть 163-178 ботиуд лам нарын сахил санваарт холбогдох зохиолууд байдаг байна. Энэтхэг, Төвөдийн олон эрдэмтэн мэргэд энэхүү сургаалыг улам боловсронгуй болгож хожмын лам хуврагуудын дагаж явах ёс журмыг тогтоож өгсөөр байжээ.

Тэдгээр мэргэдийн нэг нь Төвөд дахь шарын шашиныг үндэслэгч Богд Зонхов \1357-1419\ юм. Тэрээр бурханы шашинд шинэтгэлийн эхийг тавьсан. Энэхүү шинэтгэлийн үндэс нь Винайн \номохтгол\ үндсийг хатуу тогтоон, дээд хөлгөний ёсыг уламжлалаар гүйцэтгэн, хуврга лам нарын гүйцэтгэх үүргийг тодорхойлон, багш шавийн барилдлагат ёсыг тогтоон¹⁵ өгчээ. Шарын шашинд винай ёсыг хатуу баримтлахыг сургахдаа шагшбаад хэмээх суртахууны үндэс нь санваарын тангаргаа сахих, эзэмших ...сэтгэлийн морийг номхотгох¹⁶ хэмээн сургадаг. Монголд энэхүү шарын шашин дэлгэрсэн билээ.

Лам хүн гэдэг нь сэтгэлээ номхтгож орчлонгийн шунал хүслээс ангижирсан байх ёстой. Өөрөөр хэлбэл ...гэлэн хүн гэрээс гарч аглаг хийдэд шавилан сууж ном унших, тэдэнд өөрийн гэх гэр орон, аж ахуй, гэргий хүүхэд, эд мал тэргүүтэн үгүй байх ёстой¹⁷ байжээ. Гэтэл миний авч үзэж буй үед лам хүн сахил санваар алдах үзэгдэл тухай нийгэмд цөөнгүй гарч байсныг илтгэх олон баримтууд байна. Хууль цаазын бичгүүдэд мөн тодорхой тусгагдах болсон байдаг.

Иймээс шавийн хүн амын тал илүү хувь болсон лам нар, Их хүрээнд эрдэм сурч Эрдэнэ шанзудба, Хамба номун хан нар захирагдаж байсан лам нарын зарим хэсэг яагаад сахил санваараа алдах болсон нөхцөл шалтгааныг тухайн үеийн нийгмийн байдлаар тодруулахыг зорив.

Энэ нь дараах шалтгаануудтай болов уу. Хутагтын хүрээгээр жишээлэн үзвэл,

1. ХҮШ зуунд Жибзундамба хутагтын Их хүрээ суурьшин төвлөрч, түүнийг тойрсон сүсэгтэн олны төвлөрөл буй болж улмаар нүүдлийн өргөөнөөс суурьшсан хүрээ хот болж өргөжсөн.

¹⁴ Бурханы шашны жаяг дэг МӨЭ V-VI зууны үеэд Бурхан багш өөрийн номлол сургаалаа айлдаж дагагч шавь нартаа шашинтан хүн ямар байвал зохистойг өдөр дутмын амьдралаас эхлээд өмсөх зүүх биеэ хэрхэн авч явах зэргийг хуврагийн чуулганаар хэлэлцэж тогтоосон цагаас эхлэлтэй хэмээн үздэг. Бурхан багшийг таалал төгссөний дараа түүний айлдаж байсан сургаал, номлолыг ариунаар хадгалж, уламжлан үлдээхийг шавь нар онцгойлон үзэж, Буддагийн шавь нарын чуулганыг удаа дараа хийлгэн үүнд 3 савын ном номхтголын аймаг, судрын аймаг, илт номын аймгийг номуудыг бүтээсэн. Энэ нь Ганжуур зарлигийн хураангуй, Данжуур буюу шаштирын хураангуй болно.

¹⁵ Дагвадорж, Д. *Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг*. Улаанбаатар: 1998, 51.

¹⁶ Дагвадорж, Д. *Монголын мэргэдийн гүн ухааны цоморлиг*. Улаанбаатар: 1998, 57.

¹⁷ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал)*, Улаанбаатар: 1978, 196.

2. Их хүрээ Орос- Монгол – Хятадын худалдаа харилцааны их замын дагуу газар суурьшсан, худалдаа харилцаа өргөжин хөгжсөн нь хүрээнд суух лам нарыг энэхүү харилцаанд татагдан орох нөхцөлийг бүрдүүлсэн. Лам нар дан ганц ном үзэж сүм хийдэд суух хүмүүс төдий байгаагүй бөгөөд нийгмийн амьдралд идэвхтэй оролцогч болж хувирсан.
3. Нэг айл хоёроос гурван хүүгийнхээ нэгийг лам болгох¹⁸ болсон нь лам нарын тоо олшроход нөлөөлсөн. Улмаар хошуу шавиудаас лам нарыг их шавьд захируулах явдал их байснаар¹⁹ шавийн хүн амд лам нар өсөх нэг хүчин зүйл болсон. Лам олширсон нь бурханы номын ёсоор явагч нэг хэсэг, лам нэрийг зүүж сахил санваар алдаж явах нэг хэсгийг бий болгосон.
4. Монголын олон хошуу, шавиудаас лам нар шашны гүнзгийрүүлсэн боловсрол эзэмших гэж хүрээний 30 аймагт ирж захирагдан, дацангуудад суралцаж Хамба номун хан болон Эрдэнэ шанзудба нарт захирагдаж байсан нь олон лам нарын бөөгнөрлийг бий болгосон.
5. Халхын бурханы шашны тэргүүн монголчуудын оройн дээд лам VIII Богд Жибзундамба хутагт 1885-1886 оны орчим Дондогдуламтай²⁰ танилцан

¹⁸ Лам болохын давуу талыг акедимч Ш. Нацагдорж дараах байдлаар авч үзсэн байдаг.

-лам болох нь хамжлагын байдлаас гарч байгаа хэрэг

-лам нарыг цэргийн албанаа дайчилдаггүй байв

-лам нарт албан татвар ноогдовч харчуудыг бодвол арай хөнгөн

-лам нар ял үйлдвээс урьдаар санваарыг эвдэж, сая шийтгэх

-лам байх нь бурханы шавь хэмээн олонд хүндлэгдэх талтай

-лам байх нь ном уншиж өргөл барьц авах, мэргэ төлөг үзүүлэх, эм барих зэрэг орлого олох бололцоотой гэсэнтэй санал нэг байна. Эдгээр хүчин зүйл монголчуудын дунд лам болох үзэгдлийг нэмэгдүүлсэн.

¹⁹ Тухайн пийгэмд Жибзундамба хутагтын харьяат болох нь хуврага нарын хувьд нэр хүнд, сэтгэл зүйн хувьд таатай, харьяат хийд дацангуудад суралцаж эрдэм номоо гүнзгийрүүлэн үзэх боломжийг бий болгохын сацуу өөрийн амраг садан, хамжилга ардын ахуй амьдралыг сайжруулах нэгэн боломж гэж үзэж байсных байж болох. Мөн Чингийн төрийн бодлогоор лам нар шавь болох нь нээлттэй байсан зэргээс Их шавь дахь хүн амын тоонд ламын нарын эзлэх хувь жилээс жилд өсөн нэмэгдэж байсан.

²⁰ Жибзундамба хутагтын гэрлэлтийг судлаачид янз бүрээр бичсэн байдаг. Тухайлбал: О. Батсайхан Монголчууд Чин улсын захиргаанаас гарч төрийн тусгаар тогтнолоос эргээн тунхаглах, Халхын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагтыг хаан өргөмжлөх бэлтгэлийг эртнээс бэлдэж байсан. Шашин төрийг хослон барьсан хаант төрийг байгуулахдаа Энэтхэг, Төвөдийн төрийн уламжлал бэлгэдэл ёсыг хослуулан хэрэгжүүлсэн ба Хаан төрийн Долоон эрдэнэ хүрдэн, чандман, хатан, түшмэл, заан, морин, жанжин бүрдүүлэх ажлыг хийж байснаар илэрдэг. ...Хүний ёсонд эмэгтэй хүн бол эхнэр төдийгүй эх хүн хүн төрөлхтний нэгэн бат түшиг, тулгуур хань нь байдаг тул төр улс, айл гэрт үзэсгэлэн төгс, саруул ухаан бүрдсэн, эрдэм гүйцсэн, журамт бүсгүй нэн чухал хэмээн үзэх учир ...Богд Жавзандамба хутагт 19-дүгээр зууны сүүлчээс Дондогдуламтай ханилж, 20 дугаар зууны эхээр ...Манжийн эзэн хаандаа айлтгаж хатан Дондогдуламд Цагаан дара, Эрдэнэ сэцэн ноён хэмээх цол өргөмжлүүлсэн. ...Богд Жавзандамба гэгээнтэй албан ёсоор гэр бүл болгосон. 1911 оны 12 сарын 29 нд ...Богдын хатан Дондогдуламыг Эх дагина хэмээн өргөмжлөн, 1912 оны 2 сарын 23 нд ...Хотолыг баясагч дагина цол шагнасан. Эх дагина 1923 онд нас барсны дараа хаанд залуу хатан сонгон авч өгсөн хэмээн бичжээ. Батсайхан, О. *Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба*: амьдрал домог. Улаанбаатар: 2014, 189-190. Хаан хүн хатантай байх ёстой гэсэн зарчим үйлчилж байсан нь дараагийн үйл явдлуудаас тодорхой харагддаг. Дондогдулам хатныг 1923 оны 6 сарын 27 ны одор таалал төгссөний

дотносож гэрлэн Эх Дагинад өргөмжилсөн явдал зарим нэгэн ухвар мөчид лам нарт буруу үлгэр дуурайлал болсон байхыг үгүйсгэх арга үгүй юм.

Ийнхүү Хутагтын хүрээ Монголын улс төр, эдийн засаг, шашин соёлын төв болж өргөжин тэлснээр хүрээний лам нар худалдаа наймаа хийх, архи уух, тамхи татах, эмс охидтой холбогдох, мөрийцон тоглох, хэрүүл, зодоон хийх зэргээр лам хүний сахил санваарт харштай зүйлийг их хийх болсон байна. Энэ үзэгдэл ард олны дунд бурханы сургаал номлолыг түгээгч лам нарын нэр хүндийг унагаах болжээ.

Үе үеийн Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нараас энэхүү зохисгүй үйлдлүүдийг цаазлан зогсоох олон арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлдэг байжээ. Төрийн хууль цаазад мөн сахил санваарын алдааг хэрхэн шийтгэх тухай тусгаж өгсөн байдаг.

Иймээс энэхүү алдааг засаж залруулах гэсэн шинэтгэгч үзэлтэй лам нар гарч иржээ. Тэдний нэг Их хүрээний хамба номун хан Агваанхайдав \1779-1838\²¹-ийн үйл ажиллагаагаар жишээ татан үзэс. Тэрээр шашны сахил санваар ёс журмыг үл сахигч лам нарыг ... *шашныг баригч эзэн хэмээгчид шашин номынхоо гол ёсноос гажин, шашны нэрээр өргөл барцад шунан, ёс суртахууны хувьд доройтон буурсан нь жич \хиймлээр бологч\ гэвш гэлэн тэргүүтэн хэмээгчид үсээ хяргасан бөөрөнхий толгойт хуврагийн дүрстэнүүд шашны толгой дээр муу*

дараахан тэр зунаа Хөвчийн Жонон ван Цогтбадрахын хошуунаас 17 настай Цэнпилийг сонгон Богд хаанд хатан болгон сонгоход хаан түүнд Юмчагмаа хэмээх нэрийг хайрлан Цагаан дарь өргөмжилсөн байдаг. Тэрээр унадаг өвчтэй байсан тул Чойжин болгон Гэнэнпил гэх сахилын нэрийг хүртээж байжээ. Тэрээр 1924 оны 5 сарын 20 нд Богд хаан таалал төгсгөл Монгол төрийн хатанд өргөмжлөгдөж байсан байдаг. Мөн З.Нинжбадгар Жибзундамба хутагт, түүний дүү Чойжин лам Лувсанхайдав нар гэргий авсан учрыг ийнхүү тайлбарласан. ...Нууц тарнийн ёсны бясалгал бүтээлийн хамтрагч эх дагина буюу юм ханд....бурханы шашны дээд холгөний ёсны дандарын номлолд бурханы хутгийг олох хамгийн дөт зам нь эцэг, эх хослон бясалгал үйлдэх, Эцэг, эх ёсны бүтээлийг хэн дуртай нь үйлдэхгүй . Гагц эрдэм увдисын дээдийг ологсод үйлддэг аж. Үүнд эцэг, эх хоёул хэн хэндээ дүйцэхүйц энэ сацуутнууд байх ёстой байдаг байна. Эцэг, эх их амгалангаар ороолдсон нь арга билгийг хослуулан амт нэг болсоноор төгс гэгээрлийн хутгийг үтэр түргэн олох аргыг зохиож буй үйл ...иймээс Жибзундамба хутагт, Дондогдулам хатан нар энэ ёсны бүтээлчид байжээ. Ийм учраас Дондогдулам хатныг Цагаан дарь эх, Улсын эх дагина хэмээн өргөмжилж байв зэргээр тайлбарласан байна. Нинжбадгар, З. *Монгол төрийн Чойжин Лувсанхайдав Эх дагина Сүрэнхорлоо*. Улаанбаатар: 2016, 73-74. Өөрөөр хэлбэл бурхан бурхантайгаа гэрлэсэн эгэл хүмүүс дуурай ёсгүй гэсэн санааг гаргасан бололтой.

²¹ Агваанхайдав Түшээт хан аймгийн Дархан Чин вангийн хошууны нутагт 1779 онд төрсөн. Бага наснаас Дашчойнгэл дацанд сууж буддын гүн ухааны номыг үзэж судалсан. Төвөдийн Гомон дацанд буддын гүн ухааны мэдлэгээ дээшлүүлж равжамба болж байжээ. Тэрээр Их Хүрээний Хамба номун ханы албыг 1832-1838 оны хооронд хашиж байхдаа хүрээний лам нарын жаяг дэг журмыг чангатгаж, хичээл сургуулийн чанарыг сайжруулж байжээ.

явдлыг сахилаар доройтуулах тэргүүтэн үнсийг уул мэт овоолж байна²² хэмээн шүүмжилж байжээ. Шашныг шинэтгэх гол зорилгодоо шашны ёс журам зөрчигдөх болсон шалтгааныг сахил санваарын үндэс болох Винай ёс алдагдсантай холбон үзжээ. Винай ёсны Винайн үе гишүүний сургаалийг засан үйлдэхүйн тийн асуудал, Ламын гүн мөрний налжирийг сэтгэлдээ авах ёсон зэрэгт судруудад тайлбар хийж, мөн хуврагуудын дунд винай ёсыг чанд баримтлахад анхаарч Винайн номлол дагуу жаяг дүрэм зохион сүм хийд дацангуудад *Төгс баясгалант өрнөн дэлгэрэх хийдийн дагах журам*-ыг боловсруулан мөрдүүлж байсан байна.

Мөн тэрээр 1829 онд Эрдэнэ шанзудба Да лам нартай хамтран ... лам нар харилцан цугилдаж, занчилдах, хороо харчуудын гэрт өнжин айраг архи ууж явбал шарыг шувталж, нэг сарын дөнгө зүүлгээж, зуун ташуур занчих, Хүрээний лам нарын гэрт харчууд, эмс охид орж өнжиж болохгүй, хэрвээ үүнийг зөрчвөөс лам нарын нэгэн адил залхаан шийтгээ²³ гэсэн дүрэм тогтоон хэрэгжүүлж байжээ. Гэсэн хэдийч энэхүү хэрэг зөрчил тасралтгүй гарч байсныг илтгэх олон баримт, удаа дараа зохиосон дүрэм журмууд энэ талаар удаа дараа байнга дурдаж байснаас харж болно. Тухайлбал: 1866 онд Хүрээ сайдын газраас лам нар хэрэн явж хэрэг дэгдээх, эмс охидтой холбогдох хэрэг гарсанд 13 зүйл дүрэм,²⁴ 1873 оны хүрээний газарт эмс охид лам нарыг хольцолдуулан байлгахыг бүрэн цаазлан хориглосон бичиг,²⁵ 1905 онд идэр залуу лам нарыг дэмий шалтаг заан хүрээнээс гадагш гарах явдлыг хориглосон журам,²⁶ 1909 онд, зүүн хоёр аймаг, шавь нийлж хүрээний зэрэг газрын лам нарын муу самуун явах зэрэг гажуу сурталыг цаазлахын учир 32 зүйл дүрэм²⁷ уг дүрмийг 1910 онд засан сайжруулж ...хүрээний газрын элдэв зүйлийг ариутган цаазалж шарын шашны үндсийг зузаатгах үүнийг эрхлэх ёсыг барьж дүрэм хэмжээ тогтоосныг бага сага залруулан засамжилж тогтоон²⁸ мөрдүүлсэн байдаг. Улмаар хожим Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн 12 дугаар зүйлд бүтнээр оруулж өгснөөр лам нарын давхаргын сахил санваарын шинж чанартай, өмнө хэрэгжиж байсан зохицуулах дүрмийг, хааны лүндэнгээр баталгаажуулан, Монгол улсын хэмжээний бүх сүм хийд лам нарын дагаж мөрдөх дүрэм журам болгон өөрчилсөн байна.

²² Дагвадорж, Д. *Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цолморлиг*. Улаанбаатар: 1998, 145.

²³ Нинжбалгар, З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхт)*. Улаанбаатар: 2014, 144.

²⁴ МУУТА. М-85. Д-1. ХН-339, 90-101.

²⁵ *Их хүрээний 30 аймаг*. Улаанбаатар: 2015, 29-30.

²⁶ Мөн тэнд, 72-73.

²⁷ МУУТА. М-85. Д-1. ХН-1400.

²⁸ *Их хүрээний 30 аймаг*, УБ., 2015:85.

Жинхэнэ дагаж явах хууль, дүрмийн 12 дугаар зүйлд²⁹ дараах зохицуулалтуудыг хийж өгчээ.

- 1-р зүйл ...*Хүрээний дотроо эмсийг халган агуулгах ба мөн аливаа лам нар хороо хөдөө аль газар боловч эмс охид дугаа хольцолдон муу самуун явахыг үүрд чангалан цаазалсугай* хэмээн дүрэм тогтоож. Доорх нарийвчласан зохицуулалтыг хийж өгчээ.
- 2-9-р зүйлд лам нар Тэмдэгт бичгийн тухай өгүүлсэн бөгөөд энэ нь лам хүн албаны хэргээр харчуудын газар очих, хөдөө газар явах зэрэгт аймгийн гэсгүйгээс болон бусад албан яамдаас зөвшөөрөл тэмдэгт бичиг авах, хугацаа хэтрэх зэрэгт шийтгэл оноох тухай тусгагдсан байна.
- 10-12-р зүйлд Зөвшөөрөлгүй хороо харчуудын газраа явсан лам нарыг шийтгэх тухай
- 13-р зүйлд Хүрээний лам нарын явах газрыг нарийвчлан заан өгөхдөө ... Хүрээний лам нар хуралд хурах багшид учирч ном заалгах хүрээ эргэн буян үйлдэх хэргээр шөнө өглөө үдшийн цагт Хүрээ, Гандантэгчилэнгийн хооронд явах болбоос иргэдийн их чөлөө гудамжаар явуулъя ... зөрчвөөс гэсгүй нарт тушаан өгч бэрээгээр занчуулан 100 мөргүүл хэмээсэн байна.
- 14 –р зүйл лам нар хөдөө орон нутаг явахдаа чөлөө гуйн үнэмлэх бичиг авах, чөлөө эс авсан хугацаа хэтэрсэн зэргийг шийтгэх
- 16-р зүйл Лам нар энгийн хувцас өмсөх, гээг тавихыг хориглох
- 24-р зүйл Лам нар архи уух, худалдах
- 25-р зүйлд Мөрийцөн тоглох гэх мэт зүйлсийг хориглосон заалтуудтай.

...Энэхүү дүрэм хэмжээг олон аймаг шавийн газраа өөр өөрийн харьяат шар хар эмс охид хүртлээ нэг хэмээн дутуулахгүй нийтээр зарлан ухуулж нэгэн дугаа журамлан дага хэмээн лам нарын сахил санваар, сахилга батын асуудлыг Монгол улсын бүх сүм хийдүүдийн дагаж явах журам болгож өгсөн байна.

Чингээд 1918 оноос мөрдөж эхэлсэн Зарлигаар тогтоосон Монгол улсын Хууль зүйлийн бичгийн Лам нарын хуульд дээрх дүрмийн нарийвчилсан зохицуулалтуудыг оруулж өгөөгүй ба лам нартай холбоотой аливаа заалтуудыг Чин улсын үеийн хууль цаазын бичгүүдийн адил зохицуулалтаар оруулж өгчээ (жич, хавсралтаас үзнэ үү).

Чин улсаас монголчуудад мөрдүүлж байсан хууль цаазын бичгүүдэд лам нартай холбоотой заалт, тухайлбал: Лам нарын суусан хүрээнд эмс охид хольцолдон суухыг хориглосон заалт ...1795 оны Монгол цаазын бичгээс эх үндэстэй бөгөөд үүнийг уламжлан ЗТГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичиг, ЗТМУ-ийн хууль зүйлийн

²⁹ Жинхэнэ дагаж явах хууль дүрэм \эх бичгийн судалгаа\, Б.Баярсайхан, Ж.Урангуа, УБ., 2004:185-263.

бичиг-т тус тус мөн адил зохицуулсан³⁰ байна. *Жич: Харьцуулалтыг хавсралтаас үзнэ үү.*

Хуулиудад лам нарын өмсгөл, магад гарах тэмдэгт бичиг олгох тухай, зоргоор лам болохыг хориглох зэрэг 11 заалтыг адил агуулгатай оруулсан байна. ЗТМУ-ийн хууль зүйлийн бичигт өмнөх хуулиудад байхгүй нэг шинэ заалтыг орсон нь Лам нарын хуулийн 36 дэвтэр доод аливаа лам банди нарыг сурган цаазлах хэсгийн нэгэн зүйлд *...Аливаа лам банди нар гэрээс гарч магад гарч сүмд сууж сургагч багшийг шүтэж бурхны ном эрдэмд боловсрон сурагтун. Санваар шагшаабадыг ариунаар сахиж Богд Зонховын номлосон бодь мөрийн зэргийг дагаж явуул. Бүү эмс лугаа хольцолдож санваар шагшаабадыг шантруул. Бүү архи дарс ууж олон гэмийг одүүл. Бүү мөрийцэн наадаж эдийг бүрэлгэ. Бүү дэмий явж суртлыг цалгардуулагтун. Зөрчин явах нь буй бөгөөс хууль ёсоор ялла³¹ хэмээн лам хүний сахил санваартай холбоотой заалтыг төрийн хуулиандаа оруулж өгчээ. Энэ нь Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн заалтууд юм.*

Хууль дүрмийн хэрэгжилтийн тухай

Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм сүм хийдийн дотоод дүрэм болж сүм хийдүүд хаагдах хүртэл хэрэгжсээр байжээ.

Дээрх дүрэм гарсан даруйдаа буюу 1913 оноос хэрэгжиж эхэлснийг батлах баримт олон байна. Тухайлбал, Олноо Өргөгдсөний 3 он \1913\ Цаазалсныг зөрчин хорооны газар хар дүрмийн хувцас хэрэглэн эмс охид лугаа зууралдсан Шүтээний аймгийн лам Түвдэнгийн хэрэг ... *Би Чихийн дарга Навааны отгийн хүн эдүгээ хүрээний Шүтээний аймагт эгч чавганц Гунгаагийн хамт суудаг. ...урьд үл таних хүүхэн лугаа зээлийн газар уулзаж...түүний хамт тэдний гэрт очоод байтал урьд таних зайсан Цэндийн хүү Гомбо орж ирээд Түвдэнд хар дээл өг би хорооны газраар айл хэсмүй гэсэнд ...би хүүхний дээлээс нэгийг өмсөж ...хэд хонгоор харил үгүй хүүхэн лугаа сэтгэл барилдан байтал харьяат газраас миний биеийг элч дуудан ирсэн³² хэмээн хэргээ хүлээсэн байна. Тэрээр дүрмийн 1 дүгээр зүйл эмс охидтой явсан, 10 дугаар зүйл хороо харчуудын газраар зөвшөөрөлгүй явсан, 16 дугаар зүйл хар дүрмийн хувцас хэрэглэн явсан зүйл заалтуудыг зөрчсөн тул ...Түвдэнг дүрэм ёсоор шарын шувталж 45 одор дөнгө дөнгөлж хүрээний 30 аймгийн банданийг өдөр тутам ээлжлэн дүүргэсэн хойно 100 танишуур нэвширтэл*

³⁰ Баярсайхан, Б., Урангуа, Ж. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа)*, Улаанбаатар: 2004, 16.

³¹ *Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг*, Улаанбаатар: 2010, 169.

³² МУУТА. А-74. Д-1. ХН-983. 30 нуг.

занчиж шийтгэн түүнийг харьяат аймгийн гэсгүй нарт тушаан өгч дахин лам болгон Цогчин хуралд 200 өдөр өнжүүлэхгүй хоргуулж өдөр дутам нэжгээд 100 мөргүүлэн³³ шийтгэсэн байна.

Олноо Өргөгдсөний 4-өөс 8-р онд \1914-1918\ Шавийн яаманд шүүн шийтгэсэн 50 орчим хэргээс³⁴ сүм хийд, лам нартай холбоотой 29 хэрэг байна. Үүнээс Их шавь, Нийслэл хүрээний лам нар эмс охидтой холбогдсон 2, мөрийтэй тоглосон 1, архи уусан 9, хулгай хийсэн 3 хэргийг дүрэм ёсоор болон өмнөх хууль ёсоор шийтгэсэн байна.

Архитай холбоотой хэргийг жишээ болгон авч үзье. Олноо Өргөгдсөний 4 онд \1914\ Эрхэмийн аймгийн хаалгач Цэдэнбалжир архи ууж согтуурсан тул ...шарыг шувталж 45 хоног дөнгө дөнгөлж өдөр дуусмагц 100 ташуур занчин³⁵ дүрэм ёсоор шийтгэжээ. Өөрийн үзсэн 8 хадгаламжийн нэгжийн дотор архи уусан хэрэг 9 удаа гарч байгаагаас харвал архи уух явдал лам нарын дунд элбэг байсны илрэл юм.

Бурханы шашинд архийг гэм бүхний эх, архийг ууваас лам хүн сахил санваараа алдахын эхлэл гэж үзэх учир гэлэн хүний тэвчвэл зохих 253 сахилын 127-д архи дарс үл ууна³⁶ гэсэн тэвчилийг оруулсан байдаг. Иймээс үе үеийн эрдэмтэн лам нар архины гэмийг өөрийн бүтээл туурвилд өгүүлсээр байжээ. Тухайлбал, Ганжуурваа ламын Судраас гарсан чухал суртгаал хэмээх оршвой гэх зохиолдоо архины гэмийг ийн өгүүлжээ.

... Гэм бүхний ёзоор архийг тэвчих хэрэгтэй

Архи уусан хүний оюун санаа доройтно

Архи уусан хүний мунхаг арвижна

Архиар ичгүүр сонжуур бүхэн лугаа барилдан

Архиар хамаг хилэн бадрана

Архиар хүсэл тачаал ус мэт оргилно хэмээгээд

Убааш архи ууваас уухилагч тамд магадтай одохын судрыг зарлиглав

Барма равжсүн сахилт бээр архи ууваас их уухилагч хийгээд

буцалмал усны тамд унана

Гэцэл бээр архи ууваас халуун тамд магадтай унана

Гэлэн архи ууваас маш халуун тамд магадтай унана³⁷ гэж сургаж байжээ.

³³ МУУТА. А-74. Д-1. ХН-983. 30 нуг.

³⁴ МУУТА. А-74. Д-1. ХН-228, 229, 411, 431, 459, 469, 499, 582.

³⁵ МУУТА. А-74. Д-1. ХН-229. 16 нуг.

³⁶ Бурханы шашны нэвтэрхий толь. Улаанбаатар: 2015, 53.

³⁷ Булган, Т. Буддын ёс зүй, гүн ухааны сургаалын эмхтгэл. Улаанбаатар: 2016, 100-119.

Гэсэн хэдий ч лам нарын архи уух явдал аль ч үед гарсаар байсныг хууль цаазын бичгүүд дэх архитай холбоотой зүйл заалтуудаас харж болно.³⁸

Миний үзсэн баримтын хүрээнд Жибзундамба хутагтын харьяат хүрээ хийдийн лам нараас 1724 онд *...Нэгэн өчүүхэн банди архи ууж баригдсан тул ер хойно гагц энэ самуун зохисгүй явдал лам нарын зохиол ба шажины ёсонд үл болохын тул ...Хамба номун хан лобумба мэргэн цорж Манзушир хутагт, Эрдэнэ шанзудба болон гэсгүй нар бүгдээр хэлэлцэн Яамны Халх журамд ...Гэлэн хүн архи ууваас 9 соёолон морь, Банди нар ууваас 3 соёолон мориор баалах эднээс авсан бааны морийг гэрчид өгөх ... Гэлэн гэгцл банди хэнийг ч архи ууваас их хуралд зэд манз чанаж цогчин занданг гэлэн 21, Гэгцл 14, Банди 7 уншиж хуралд мөргүүлэе. Зэд манз чанах юмгүй хуврага архи ууваас манзын ёсыг цаазын хувингаар 3 сар өдөр бүр ус зөөлгө дуусаад мөн ёсоор хуралд наминчил. Залхалгүй дахин архи ууваас шажиныг ёс дууссан тул хулгайчын ёсоор жил дуустал хадъя дуусаад мөн ёсоор наманчилна. Архи уусан хуврагийг номын засгийн лам мэдтүгэй³⁹ хэмээн цааз тогтоон мөрдүүлж байсныг 1754 онд *... Гэлэн хүн архи ууваас 3 морь баалъя. Гэгцл хүн архи ууваас 2 морь, Банди 1 морь баалъя*⁴⁰ гэж шинэчлэн баталсан байна. Улаан хацартад 1864 онд архи уусан лам нарыг *...архи ууж согтоод түшмэл зайсан Балин лугаа хэрэлдсэн лам Чимэд, Гомбо нарыг тус бүр хуулийн нигжгээд есөн малаар торгон шийтгэсэн*⁴¹ нь гэлэн хүн архи ууваас есөн соёлон мориор торгох⁴² Халх журмын ёсоор шийтгэсэн байна.*

³⁸ Монголчуудын дунд бурханы шашин дэлгэрсэн үеэс л хууль цаазын бичгүүдэд лам хүн архи ууваас хэрхэхийг цаазлан өгч байсан байна. Хубилай хааны зохиолгосон Арван буянт номын цагаан түүхэд *...тойн хүн санваарыг эвдэж ...дарс ууж худлыг өгүүлэх олхихуй үгсээр хоёр төрийг эвдэх тэргүүтнийг үйдвэл тойны санваарыг байлгуулж эглийн ёсонд оруул. Хоёр гарыг нь маш чанад хүлж нүүрийг нь хар бэхээр эрээлэн оройд нь хар хиар хатгаж хар цалмаар хөтлөөд алтан бэрээгээр хонгыг нь нишгээж сүм хийдийг гурвантай буруу эргүүлээд хол газар цөлж орхитугай* хэмээн архи уусан ламыг шар шувтлан хар болгох шийтгэл оноож байсан бол 1640 оны Монгол Ойрадын Их цаазад *...Тойн хуврагийн ёсонд шагшаабад тэргүүтний тул ерөнхий бүгдээр өөр өөрийн зарчмыг ёсчлон тэтгэ ... гэлэнгүүд дорвон буурал их гэмийн үндэс мөний тул хэрвээ магад гэмтэй болхул дөнөн тэмээ авч, архи уусныг хэн үзсэн хүн гунан морь ав. Гэгцэлүүдэд тэр мэт буурал болхул дөнөн морь ав. Архи уусныг гунан хонь ав. Банди нар тэр мэт буруу явхул гунан хонь ав. Архи уухуна таван мөнгө ав. Хэнд ч шандасба болхул хагацтугай. Эс орхивоос хуралд бүү оруул. Хүнийг гүрэмд бүү явуул гэж цаазлан. Энэхүү цаазад архи уусан лам нарыг сахил санваарын зэргээр торгуул шийтгэлийг онуулах, архи уусан этгээдийг барьж өгсөн хүнийг урамшуулж байхаар цаазалсан нь хожмын хууль дүрмүүдийн загвар болжээ. Монгол улсын арван буянт номын цагаан түүх, Монголын төр эрх зүйн (дээж бичиг) 1-р дэвтэр. Улаанбаатар: 2006, 13. Монгол Ойрадын их цааз, Монголын төр эрх зүйн (дээж бичиг). 1-р дэвтэр. Улаанбаатар: 2006, 48.*

³⁹ Халх журам, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Улаанбаатар: 2010, 159.

⁴⁰ Халх журам, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Улаанбаатар: 2010, 161.

⁴¹ Баярсайхан, Б., Батбаяр, Б., Лхагважав, Б. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт). Улаанбаатар: 2010, 76.

⁴² Халх журам, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Улаанбаатар: 2010, 159.

Энэ мэт лам нартай холбоотой хэрэг зөрчлийг Эрдэнэ шанзудба, Хамба номун хан нар шийдвэрлэсээр иржээ. Мөн лам нарын сахил санваарыг ариун журамтай байхын тухайд дүрэм журмуудыг боловсруулан өөрийн харьяат Их шавийн олон хүрээ хийдүүдэд сахин мөрдүүлэх ажлуудыг хийсээр байжээ.

Ийнхүү төрийн хууль цаазаар дамжуулан лам нарын сахил санваар зөрчсөн асуудлыг таслан зогсоох нь зүйн хэрэг боловч, лам хуврага хэт олширч лам нарын гэх олон давхраажилт бүхий давхарга оршин тогтнож байсан нь Монголын нийгэмд зарим нэг сөрөг үр дагаврыг авчирсан байдаг. Тухайлбал, Их шавьд хүн амын өсөлт тогтмол буурч харин лам нарын эзлэх хувь тогтмол өсөж байсан нь шавийн хүн амын нөхөн үржихүйг зогсонг байдалтай болсныг дээр дурдсан баримтаас харж болно. Лам хүн эмс охидтой холбогдох хэрэг түгээмэл гарах болсон нь монголд эцэг нь тодорхойгүй бутац хүүхдийн тоо олширход нөлөөлсөн байна. Жишээ дурдвас, 1921 онд Нийслэл хүрээнд бага сургууль байгуулагдан дөрвөн аймаг шавиас 61 хүүхэд сурч байсны 27-н их шавиас сурч байжээ. Сурагчдын бүртгэлд уг 27 хүүхдийн 9 –н эцгээрээ овоглосон бол 16-н эхээрээ 2 хүүхдийн овог тодорхой бусаар бүртгэгдсэн⁴³ байх юм. Мөн Их хүрээний Бизьяагийн аймгийн лам нарын 1937 оны бүртгэлд⁴⁴ байх Төв аймгийн Авзага хайрхан уулын 28 ламын 6 нь бутац гэсэн овгоор тэмдэглэгдсэн байгаа зэргээс лам нарын хэт олширол монголын нийгмийн хүн ам зүйн асуудалд сөрөг хүчин зүйлийг бий болгож байсны жишээ юм. Энэ үзэгдэл ганц Их шавьд тулгарсан асуудал биш, Монголын даяар болж байсан үзэгдэл үйл явц байжээ.

Дүгнэлт

Буддын шашинд лам хувраг хүний ариун ёс суртахуун, мөрдөж явах жаяг, сахил санваарыг Бурхан багшийн үеэс зарлиглаж ирсэн. Хожим нь шашны холбогдолтой хууль дүрэмд зохих тусгалаа олсон байдаг.

Сахил санваарын ёс зүйгээ сахих нь чухал. Учир нь тэд нийгэмд асар нөлөөтэй нийгмийн давхарга. Лам хүн гэдэг ард олонд тулгарсан бэрхшээл саадыг оюун санаа, итгэл бишрэлээр зохицуулагч, багш хэмээн хүндлэгдэж, нийгэмд зөв үлгэр дуурайлал болох хүн юм. Сахил санваарын амлалт нь өөрөө нийгмийн зөв хэм хэмжээ. Гэтэл дээр өгүүлсэн олон шалтгааны улмаас ёс зүйгүй үйлдэл гаргах болсон нь үе үеийн хууль цаазуудад тусгагдах болжээ.

⁴³ *Ахмад данс хараачдын бүтээлийн чуулган*. Тэргүүн боть, Улаанбаатар: 2017, 254-260.
⁴⁴ МУУТА. Х-198. Д-1. Хн-16.

Жинхэнэ дагаж явах хууль дүрмийн зүйл заалтууд нь Олноо Өргөгдсөн Монгол улсын үед шинээр хэрэгжүүлсэн дүрэм биш. Өмнө Их хүрээнд хэрэгжиж байсан хэм хэмжээг уламжлан мөрдүүлсэн дүрэм юм. Сүм хийдүүдийн дотоод дүрэм жаягийг Монгол улсын хэмжээнд хэрэгжүүлэх, дагаж явах дүрэм болгосноор Зарлигаар Тогтоосон Монгол улсын Хууль Зүйлийн бичигт өмнөх хууль цаазад байгаагүй зарим нэгэн зүйл заалтыг шинээр оруулж өгсөн байна. Энэхүү өгүүлэлд Их хүрээгээр жишээлэн үзсэн учир лам нарын сахил санваар алдагдах зөрчил их гарах болсныг Их хүрээний суурьшихтай холбон үзсэн болно. Хуврага лам нарын гэм алдааг засахын тухайд эрдэмтэн лам нар шашны сургаал зохиох, винай ёсны судруудад тайлбарлан хийн шавь нартаа ухуулан ойлгуулах, дүрэм журам боловсруулан мөрдүүлэх, хутагт хувилгаадаас лүндэн зарлигуудыг гарган засах оролдлогыг тухай бүрд хийсээр иржээ.

Гэсэн хэдий ч тухайн цаг үед лам нарын сахил санваар алдах үзэгдлийг гэмт үйлдлийн түвшинд авч үзэж төрийн хууль цаазуудад оруулж, шийтгэж байсан ч энэхүү асуудал бүрэн шийдэгдэх боломжгүй байсан бололтой.

Монголын нийгэмд лам нарын гэх давхарга бүрэлдэн бий болсон, лам хүний хатуу чанга сахил санваарын тэвчил нь тухай үеийн монголчуудад сөрөг үр дагаврыг авчирсан байна.

Abstract: On December 29, 1911 the Mongols declared their independence from the collapsing Qing Empire and installed as theocratic sovereign the 8th Bogd Gegeen, highest authority of Tibetan Buddhism in Mongolia, who took the title Bogd Khaan or “Holy Ruler”. Hence, many reform policies have been introduced to reform the country, including legal reforms. Among all of the reforms, firstly abolish the laws and regulations of Qing dynasty, under the legal reforms, the document was followed by the Act of Authentic Relevance (1913). It was a manifestation of the rules governing multiple social aspects of life until the adoption of a new law in the country. Article 1 and 12 of the Law provided that the precept details of the monastic discipline of a monk, a large group of Mongolian society. Therefore, article will discuss the reasons of these precepts specifically reflected in their laws. Moreover, author intended to clarify and explain the reasons why breaking the precepts issues became common among the lamas. When was the rule of the framework to stop this problem and when these rules reflected in the laws in first place and how they were punished through the use of legal documents by using the archived relevant documents of the Act of Authentic Relevance (1913) and archived documents of the Ministry of Shavi in the Mongolian National Archives.

Ном зүй

Архивын баримт:

1. МУҮТА. А-74. Д-1. ХН-228, 229, 327, 411, 431, 459, 469, 499, 582, 983
2. МУҮТА. М-85. Д-1. ХН-339, 1400

Баримт бичгийн эмхтгэл:

1. Булган, Т. Буддын ёс зүй, гүн ухааны сургаалын эмхтгэл. Улаанбаатар: 2017.
2. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Улаанбаатар: 2010.
3. Жинхэнэ дагаж явах хууль дүрэм \эх бичгийн судалгаа\ . УБ.,2004
4. Их хүрээний гучин аймаг. Улаанбаатар: 2015.
5. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт). Улаанбаатар: 2010.
6. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Улаанбаатар: 2010.
7. Historia Mongolarum. №267 (33), 2011.

Судалгааны бүтээл:

1. Болдбаатар, Ж. Монголын бурханы шашны лам хуврага. Улаанбаатар: 2010.
2. Дагвадорж, Д. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. Улаанбаатар: 1998.
3. Майский, И. М. Орчин үеийн Монгол. Улаанбаатар: 2001.
4. Нацагдорж, Ш. Монголын феодализмын үндсэн замнал. Улаанбаатар: 1978.
5. Нийслэл хүрээ 100 жил эрдэм шинжилгээний эмхтгэл. Улаанбаатар: 2012.
6. Нинжбадгар, З. Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхэн). Улаанбаатар: 2014.
7. Содовсүрэн, Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). Улаанбаатар: 1989.

Толь бичиг:

1. Бурханы шашны нэвтэрхий толь. Улаанбаатар: 2015.